


Сэдэв 2. Зардлын шинжилгээ, бүтэгдэхүүний өртөг тооцоолол

П.Жаргалтуяа /Доктор(Ph.D)., профессор/

Агуулга

- 1. Зардлын ангилал, шинжилгээ**
- 2. Бүтээгдэхүүний өртөг тооцоолол**
- 3. Бүтээгдэхүүний өртөг тооцох уламжлалт болон орчин үеийн аргууд**
- 4. Дасгал ажил: Үндэсний үйлдвэрлэлийн кэйс**

1. Бүтээгдэхүүний өртөг тооцох нь: Үйлдвэрлэлийн зардал




- Үндсэн материал
- Туслах орц, материал

- Үндсэн ажилчдын цалин хөлс
- Цехийн мастер, алба нэгжийн ахлагчдын цалин хөлс
- Ажилчдын ээлжийн амралт, сул зогсолт, нөхөн олговор, НДШ, ЭМДШ-ийн зардал
- Бусад

- Үйлдвэрлэлийн барилга, тоног төхөөрөмж, элэгдэл, хөрөнгийн татвар, түрээс, даатгалын зардал
- Түлш шатахууны зардал
- Урсгал засварын зардал
- Цахилгаан, уур ус, засварын зардал
- Бусад

Бүтээгдэхүүний нэгжийн өртгийг үйлдвэрлэлийн зардлаар тооцно.


1.Бүтээгдэхүүний өртөг тооцох нь: Үйл ажиллагааны зардал



- Борлуулалт, маркетингийн ажилтны цалин хөлс, НДШ, ЭМДШ-ийн зардал
- Тээврийн зардал
- Томилолт
- Бичиг хэргийн,
- Шуудан холбооны зардал
- Бусад зардал

- Ерөнхий удирдлагын ажилтны цалин хөлс, нөхөн олговор, НДШ, ЭМДШ-ийн зардал
- Конторын барилга, Тоног төхөөрөмжийн элэгдэл, Түрээсийн зардал
- Бүртгэлийн зардал
- Хөндлөнгийн хяналт, аудитын зардал
- Хууль эрх хүй, бичиг хэрэг, хүлээн авалт, шуудан холбоо, тээвэр, томилолтын зардал
- Бусад зардал

1.Бүтээгдэхүүний өртөг тооцох нь: Нийт үйл ажиллагааны зардал



Нийт үйл ажиллагааны зардлаар буюу бүрэн зардлаар нэгжийн өртгийг тооцож, удирдлагын шийдвэр гаргалтанд ашиглаж болно.

1.Бүтээгдэхүүний өртгийг уламжлалт аргаар тооцох нь

Ажлын захиалгын аргаар өртөг тооцох систем. Өртгийн объект нь тодорхой ажил, бүтээгдэхүүн эсвэл захиалгат, гэрээт ажлууд байна.

Ажлын захиалгын аргаар /АЗА/ өртөг тооцох системийн онцлог:

1. Захиалгат ажил бүрээр өртгийг тооцож байгаа учраас борлуулалтын үнэ, өртгийн зөрүүгээр ашиг, алдагдлыг тодорхойлох боломжтой.
2. Бүтээгдэхүүний өртөгт үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлыг урьдчилан тооцоолсон норм, хэмжээгээр шингээдэг.
3. Захиалга тус бүрээр анхан шатны баримтуудыг зааглан бүртгэж, хөтөлдөг.

1.Бүтээгдэхүүний өртгийг уламжлалт аргаар тооцох нь

Ажлын захиалгын аргын үед тодорхой бүтээгдэхүүн, ажил тус бүрээр нээсэн *Дуусаагүй үйлдвэрлэл* дансанд зардлыг хуримтлуулан бүртгэнэ.

Олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг байгууллагын хувьд бүтээгдэхүүн бүрээр Дуусаагүй үйлдвэрлэл данс хөтлөх нь бэрхшээлтэй байдаг тул захиалга бүрээр өртгийн хуудас хөтөлж, тэдгээрийн нэгдсэн дүнг Дуусаагүй үйлдвэрлэл дансанд тусгана.

Жишээ 1: “GJ” хэвлэлийн үйлдвэрийн захиалгат ажил, номны өртгийг тооцоолъё. Номны захиалга, зардалтай холбоотой мэдээлэл дараах байдлаар өгөгдсөн. Үйлдвэрлэлийн өртөг, бүтээгдэхүүний өртгийг тооцоолж, холбогдох журналын бичилт хийнэ үү.

1.Бүтээгдэхүүний өртгийг уламжлалт аргаар тооцох нь

Дуусаагүй үйлдвэрлэл

Ажлын захиалга № 250

Захиалагч: ШУТИС-ийн багш

Бүтээгдэхүүний онцлог: **50.0 хх**, хатуу хавтастай

Тоо хэмжээ: **100ш**

Захиалга өгсөн огноо: 2019, 1 сарын 4

Захиалга дуусгах хугацаа, хоногоор: 1 сарын 8, 3 хоног

Материалын зардал

Сар өдөр	Шаардах хуудасны №	Зардал /₮/	Дүн /₮/
1 сарын 5	31	500,000.00	
1 сарын 6	32	400,000.00	
1 сарын 7	33	350,000.00	
			1,250,000.00

1.Бүтээгдэхүүний өртгийг уламжлалт аргаар тооцох нь

Хөдөлмөрийн зардал

Сар өдөр	Ажилласан цаг	Зардал /₮/	Дүн /₮/
1 сарын 5	48	180,000.00	
1 сарын 6	48	180,000.00	
1 сарын 7	48	180,000.00	
			540,000.00

ҮНЗ-ыг хөдөлмөрийн зардлын 40%-иар төсөвлөж, өртөгт оруулж, тооцно

Үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал

Сар өдөр	Өртөгт шингээх хувь	Зардал /₮/	Дүн /₮/
1 сарын 5	40%	72,000.00	
1 сарын 6	40%	72,000.00	
1 сарын 7	40%	72,000.00	
			216,000.00

Номны нэгжийн захиалгын үнэ	25,000.0₮		2,006,000.00
Шууд хөдөлмөрийн зардал	1,250,000.0	Борлуулах үнэ	2,500,000.0
Шууд материалын зардал	540,000.0	Үйлдвэрлэлийн өртөг	(2,006,000.0)
ҮНЗ	216,000.0	Нийт ашиг	494,000.0
Нийт өртөг	2,006,000.0	Нэгжийн өртөг=2,006,000/100=	20,060₮

2. Бүтээгдэхүүний өртөг тооцох орчин үеийн арга

- *Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгөөр /БАМ/ өртөг тооцох арга.*

Энэ арга нь бүтээгдэхүүний өртгийг тайлант хугацаанд бус бүхий л амьдралын мөчлөгийн хугацаанд бодож, тооцоолдог арга. Бүтээгдэхүүний судалгаа, хөгжүүлэлт, дизайны загварчлалаас эхлээд бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт, борлуулалтын дараах үйлчилгээнд гарсан бүхий л нөөцийн зарцуулалтаар тооцсон өртгийг амьдралын мөчлөгийн өртөг гэнэ.

- БАМ-ийн өртгийг 3 үед хувааж болох бөгөөд дараах өртгүүд гарна.

1. Төлөвлөх, загварчлах үе. Энэ үед судалгаа, хөгжүүлэлтийн өртөг, загварчлах өртөг, маркетингийн өртгийг тооцно.

2. Үйлдвэрлэл ба борлуулалтын үе. Энэ үед үйлдвэрлэлийн өртөг, маркетингийн өртөг, түгээлтийн өртгийг тооцно.

3. Борлуулалтын дараах үйлчилгээ ба данснаас хасах үе. Энэ үед борлуулалтын дараах үйлчилгээний зардал, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг зогсоох өртгийг тооцно.

2. Бүтээгдэхүүний өртөг тооцох орчин үеийн арга

Жишээ 2. “А” компани шинэ загварын тусгай бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр төлөвлөж, хөгжүүлэлт хийсэн. Шинэ бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийг 3 жил байхаар тооцоолж байгаа бөгөөд тооцоолол нь дараах байдлаар өгөгдсөн.

Зардлын төрлүүд	20x7	20x8	20x9
Үйлдвэрлэх болон бүтээгдэхүүний тоо		6,000.0	3,000.0
Судалгаа, хөгжүүлэлтийн зардал	18,000,000.0		
Бүтээгдэхүүний загварын зардал	6,000,000.0		
Ажилчдыг сургах зардал	3,750,000.0		
Үйлдвэрлэлийн зардал:			
Нэгжийн хувьсах зардал		7,500.0	3,300.0
Тогтмол зардал		7,200,000.0	3,300,000.0
Борлуулалтын зардал			
Нэгжийн хувьсах зардал /Борлуулалтын/		1200.0	900.0
Тогтмол зардал		1,500,000.0	1,000,000.0
Маркетингийн зардал	4,500,000.0	3,000,000.0	2,250,000.0
Удирдлагын зардал	5,250,000.0	5,100,000.0	5,700,000.0
Үйлдвэрлэлд ашигласан тоног төхөөрөмжийг ашиглалтнаас хасах зардал			675,000.0

Хийх зүйл: Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн аргаар нэгжийн өртгийг тооцно уу.

2. Бүтээгдэхүүний өртөг тооцох орчин үеийн арга

Бодолт: Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгөөр /БАМ/ өртөг тооцох арга

Үйлдвэрлэлийн зардал = $6000 * 7500\text{₮} + 3000 * 3300 + 7200,000 + 3300,000 = 65,400,000$

Борлуулалтын зардал = $6000 * 1200 + 3000 * 900 + 1500,000 + 1000,000 = 12,400,000$

БАМ-ийн нийт өртөг = $18,000,000 + 6,000,000 + 3750,000 + 4500,000 + 5250,000 + 3,000,000 + 5100,000 + 2,250,000 + 5700,000 + 675,000 + 65,400,000 + 12,400,000 = 132,025,000.0\text{₮}$

БАМ-өөр тооцсон нэгжсийн өртөг = $132,025,000 / 9,000 = 14669.4\text{₮}$

Ургамал гаралтай цайны өртөг /200г/: “Байгаль цай -20”

Ургамлын гаралтай цайны өртөг /200г/ 2018, 2019 он

төгрөг

д/д		Зардлын үзүүлэлтүүд	17600 ш /80%/	19800 ш /90%/
1	Материал	Түүхий эд материалын зардал	33,000,000.0	40,837,500
2				
3	Хөдөлмөр	Цалин, НДШ-ийн зардал	61,216,500.0	67,338,150
4				
5	ҮНЗ	Цахилгааны зардал	3,008,544.00	3,309,398
6		Ус, дулааны зардал	1,805,255.00	1,985,781
7		Тээвэр, шатахууны зардал	832,000.00	915,200
8		Хөдөлмөр хамгааллын зардал	375,000.00	412,500
9		Үйлдвэр байрны түрээсийн зардал	15,000,000.00	16,500,000
10		Сав баглаа боодлын зардал	7,040,000.00	7,920,000
11		Плантацийн зардал	930,500.00	1,023,550
12		Элэгдлийн зардал	3,613,800	3,613,795
13		Үйлдвэрлэлийн зардал	126,821,599.0	143,855,874
14	Нэгжийн өртөг/Үйлдвэрлэлийн зардлаар/		7,205.77	7265.45
15	Үйл.аж. Зар	Удирдлага, борлуулалтын зардал	6,050,000.00	6,655,000
16		Зээлийн хүүний зардал	3,150,000	2,789,063
17		Бусад зардал	500,000.00	550,000
18		Татварын зардал /(10%/)	427,840.10	2,039,006
19	Нийт зардал		136,949,439.1	155,888,943
20	Нэгжийн өртөг /Бүрэн зардлаар/		7,781.2	7873.18
21	Нэгжийн үнэ		8000₮	8800₮
	Нэгжийн ашиг		218.8	926.82
	Нэгжийн ашиг/%/		2.74%	10.53%

Ургамал гаралтай цайны өртөг /200г/: “Байгаль цай -20”

Ургамлын гаралтай цайны өртөг /200г/ 2018, 2019он

д/д		Зардлын үзүүлэлтүүд	17600 ш /80%/	Хувь	19800 ш /90%/
1	Материал	Түүхий эд материалын зардал	33,000,000.0	24%	40,837,500
2					
3	Хөдөлмөр	Цалин, НДШ-ийн зардал	61,216,500.0	45%	67,338,150
4					
5	ҮНЗ	Цахилгааны зардал	3,008,544.00	2.2%	3,309,398
6		Ус, дулааны зардал	1,805,255.00	1.3%	1,985,781
7		Тээвэр, шатахууны зардал	832,000.00	0.6%	915,200
8		Хөдөлмөр хамгааллын зардал	375,000.00	0.3%	412,500
9		Үйлдвэр байрны түрээсийн зардал	15,000,000.00	11.0%	16,500,000
10		Сав баглаа боодлын зардал	7,040,000.00	5.14%	7,920,000
11		Плантацийн зардал	930,500.00	0.68%	1,023,550
12		Элэгдлийн зардал	3,613,800	2.64%	3,613,795
13		Үйлдвэрлэлийн зардал	126,821,599.0	92.6%	143,855,874
15		Үйл.аж. Зар	Удирдлага, борлуулалтын зардал	6,050,000.00	4.42%
16	Зээлийн хүүний зардал		3,150,000	2.30%	2,789,063
17		Бусад зардал	500,000.00	0.37%	550,000
18		Татварын зардал /(10%)/	427,840.10	0.31%	2,039,006
19	Нийт зардал		136,949,439.1	100%	155,888,943
20		Бүрэн зардал /өртөг/	7,781.2		7873.18
21	Нэгжийн үнэ		8000₮		8800₮
		Нэгжийн ашиг	218.8		926.82
		Нэгжийн ашиг/%/	2.74%		10.53%

Сүлжмэл цамцны өртөг тооцох нь

Сүлжмэл цамцны өртөг /Кардиган, цамц/: 2018, 2019

төгрөг

д/д		Зардлын үзүүлэлтүүд	3000 ш /60%/	хувь %	3500 ш /70%/
1	Материал	Түүхий эд материалын зардал	23,660,160	26.1%	30,363,872
2					
3	Хөдөлмөр	Цалин, НДШ-ийн зардал	44,622,000	49.2%	49,084,200
4					
5	ҮНЗ	Цахилгааны зардал	1,677,500	1.9%	1,845,250
6		Ус, дулааны зардал	145,000	0.2%	159,500
8		Хөдөлмөр хамгааллын зардал	80,000	0.1%	88,000
9		Үйлдвэр байрны түрээсийн зардал	5,352,960	5.9%	5,888,256
12		Элэгдлийн зардал	3,798,000	4.2%	3,797,995
13		Үйлдвэрлэлийн зардал	79,335,620.0	87.5%	91,227,073
14	Нэгжийн өртөг /Бүрэн зардлаар/				
15	Үйл.аж. Зар	Удирдлага, борлуулалтын зардал	7,500,000	8.3%	8,250,000
16		Зээлийн хүүний зардал	3,234,600	3.6%	3,234,600
17		Бусад зардал	500,000	0.6%	550,000
18		Татварын зардал /(10%/)	62,978	0.1%	1,377,833
19	Нийт зардал		90,633,198.0	100%	104,639,506
20	Нэгжийн өртөг /Бүрэн зардлаар/		30,211.07		29897.00
21	Нэгжийн үнэ		35000₮		35000₮
	Нэгжийн ашиг		4,788.9		5103
	Нэгжийн ашиг/%/		13.60%		14.58%

**"ВУ" оёдлын үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл
Бүтээгдэхүүний өртөг тооцоололт /Ажлын хувцас/**

№	Материалын нэр	х/н	Төлөвлөлт		
			Үнэ	Орц	Нийт дүн /төг/
А	Үндсэн материал				
1	Өнгө материал	м	-	4	-
2	Өнгө/оруулга/	м	-	0.95	-
2	Цаасан наалт/0.9 см/	м	750	1.32	990
3	Халаасны уутны материал	м	-	0.18	-
<i>Үндсэн материалын дүн</i>			750	990	990
Б	Туслах материал				
1	Утас №40 /саарал/	ярд	1.32	700	924
2	Утас №40 /шар/	ярд	1	123	162
3	Нэрийн бичмэл	ш	2000	1	2000
4	Лого	ш	4000	1	4000
5	Хатгамал	ш	1500	1	1500
7	Резин /4см/	м	836	0.72	602
8	Цацруулагч/2.5см/	м	1100	2.05	2255
9	Резин /2см/	м	320	0.84	269
10	Цахилгаан/70см саарал/	ш	1100	1	1100
11	Өлгүүрийн гогцоо	м	150	0.8	120
12	Цаасан шошго	ш	30	2	60
13	Размерийн тууз	м	100	2	200
14	Өнгийн шохой	ш	500	0.17	85
15	Бал	ш	200	0.01	2
16	Кноф	ш	40	5	200
17	Товч/саарал/	ш	120	1	120
18	Сум	ш	1	1	1
19	Гялгар уут	ш	360	1	360
<i>Туслах материалын дүн</i>					13960
МАТЕРИАЛЫН ДҮН					14950

"ВU" оёдлын үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл
 Бүтээгдэхүүний өртөг тооцоололт /Ажлын хувцас/

В	<i>Оёдлын хөлсний дүн</i>		
1	Эсгүүрийн хөлс		6006
2	Оёдлын хөлс		45218
3	Гүйцэтгэх тасаг		4040
Нийт оёдлын хөлсний дүн			<u>55264</u>
Г	<i>Үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал</i>		
3	Нэмэгдэл цалин		
4	Үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал		38684.8
<i>Нэмэгдэл зардлын</i>			<u>38685</u>
Бүтээгдэхүүний нийт өртөг			<u>108899</u>
1	Ашиг	15%	16335
2	Бүтээгдэхүүний үнэ		125234
3	НӨАТ 10%		12523
Бүтээгдэхүүний зарах үнэ			<u>137757</u>
			<u>138000</u>

Баярлалаа 😊